



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comsog@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.01.29 № 01/1800
танай _____-ны № _____-т

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ш.ЭНХТУЯА ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас 2023 онд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт ажиллах явцад тогтоогдсон нөхцөл байдалтай холбогдуулан Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай Зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжид дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэн Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

Хавсралт 6. хуудастай.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ

142403001564

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт ажилласантай холбогдуулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж байна.

Зөвлөмж 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, түүнд тавих хяналтыг сайжруулах, ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд зохих хариуцлагыг ногдуулдаг байх;

Зөвлөмж 2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагаас хүргүүлсэн санал, зөвлөмж, үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлэх, хууль зөрчсөн аливаа үйлдлээс зайлсхийх, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх;

Зөвлөмж 3. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах, цахим системд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний нотломжийг хавсаргадаг байх;

Зөвлөмж 4. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийтлэг үүргээ хэрэгжүүлэх, хуульд зааснаар авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд холбогдох хариуцлагыг ногдуулдаг байх;

Зөвлөмж 5. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр томилох, томилсны дараа хянуулах зөрчлийг таслан зогсоох, цаашид энэ төрлийн зөрчлийг давтан гаргахгүй байх;

Зөвлөмж 6. Төсвийн төлөвлөлтийг сайжруулах, төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг баримтлах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлж ажиллах;

Зөвлөмж 7. Худалдан авах ажиллагааг хууль журамд заасны дагуу төлөвлөн хэрэгжүүлдэг байх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн ажилтнуудын тоог нэмэгдүүлэх, Үнэлгээний хороог байгуулахдаа ажилтнуудын худалдан авах ажиллагаанд оролцсон давтамжийг харгалздаг байх;

Зөвлөмж 8. Төсөл, хөтөлбөр (төсөв)-ийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахгүй байх, уг хөрөнгөөс байгууллагын албан хаагчдад болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд урамшуулал олгож байгааг таслан зогсоох, 2022-2023 хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд дотоод шалгалт хийж холбогдох арга хэмжээ авах.

Зөвлөмж 9. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны явцад гарч буй хүндрэл, бэрхшээлийг арилгах, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, програм хангамжид хөгжүүлэлт хийх, цахим системийн найдвартай байдлыг хангах;

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР